



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/31

Мандалговь

Хүүхдийн өөрөө удирдах байгууллага,
клубийн үйл ажиллагааг дэмжих тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.5, Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын А/30 тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн хөгжил, оролцооны хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубийн үйл ажиллагааг дэмжин түүний үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор Дундговь аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубүүдийн дунд төслийн уралдааныг 2021 оны 03 дугаар сарын 05-аас 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулж, шалгарсан төслүүдэд санхүүгийн дэмжлэг олгосугай.

2. Хүүхдийн хөгжил, оролцооны хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубийн шалгарсан төслүүдийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Шалгарсан хүүхдийн хөгжил, оролцооны хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубүүдийн төсөлд шаардагдах 2.480,250 (Хоёр сая дөрвөн зуун наян мянга хоёр зуун тавин) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Чинбат/-д зөвшөөрсүгэй.

4. Хүүхдийн хөгжил, оролцооны хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубүүдийн санхүүжилтийн зарцуулалт болон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Отгонсүрэн/, гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны үр дүнг 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Отгонсүрэн/-д даалгасугай.


ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

481190062

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 07 дүгээр сарын 09 ний өдрийн А/3.1 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



ШАЛГАРСАН ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

№	Клубийн нэр	Харъяалагдах байгууллага	Үйл ажилгааны чиглэл	Шаардагдах төсөв
1	Хамтдаа сэргийлье	Цэгц билиг сургууль	Хүүхэд өсвөр үеийнхэнд хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх	350,000
2	Ирээдүй СӨУБ	Хүмүүнлэг сургууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар хууль суртчлах, таниулах	348,750
3	Гэрэлт цамхаг	Сайн дур	Ажил мэргэжил амьдрах ухааны	350,000
4	Smart kids	Говийн ирээдүй цогцолбор сургууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар хууль суртчлах, таниулах	350,000
5	Нахиа	Говийн ирээдүй цогцолбор сургууль	Байгаль орчноо хамгаалах, эко орчныг бий болгох	346,500
6	Донж	Өлзийт сумын ерөнхий боловсролын сургууль	Ажил мэргэжил амьдрах ухааны	350,000
7	Бидний дуу хоолой	Эрдмийн далай цогцолбор сургууль	Ажил мэргэжил амьдрах ухааны	350,000
8	Батламж	-	-	35,000
Нийт				2,480,250

----oOo----